

ЖАЛХАНЗ ХУТАГТ ДАМДИНБАЗАРЫН ХОЙД ДҮРИЙГ ТОДРУУЛСАН ТУХАЙ ЗАРИМ МЭДЭЭ

С.Янжинсүрэн (Ph.D)

Философи, шашин судлалын тэнхим
ШУС. МУИС

О.Бумдарь (Докторант)

Монголын түүхийн салбар
Монгол судлалын сургууль. ӨМИС.

Түлхүүр үгс: Жалханз хутагт Дамдинбазар, хойд дүр, Гэлэгдэмбэрэл.

Товч утга: Тус өгүүлэлд 1923 оны зун жалханз хутагт Дамдинбазарыг жанч халсны дараа хутагтын харьяат шавь ард, хийд орны лам нараас багш хутагтынхаа хойд дүрийг тодруулахыг машид хүсч, улмаар шинэ тодорсон хөвгүүнийг ширээнд нь залж, сүсгээр суулгаж, ёсоор явуулахыг ихэд хичээнгүйлсэн боловч тэдний хүсэл талаар болсон тухай түүхэн асуудлыг товчхон өгүүлэв.

Өгүүллэгийн агуулга архивын баримт, материалд тулгуурласан болно.

* * * * *

Шашин, төрийн нэрт зүтгэлтэн, Монгол улсын ерөнхий сайд агсан Жалханз хутагт С.Дамдинбазар(1874-1923)-ын хойд дүрийг тодруулан залах тухай анх 1925 онд тухайн үеийн Хан тайшир уулын аймгийн Дэлгэрхан уулын хошуунд хавсарган захирагдсан Өлзийт Баянзүрх уулын хошууны Жалханз хутагтын Равданчойнхорлин хийдийн хамба, цорж, мэдээчин, хар шар олон шавь нараас самади багш Жалханз хутагтын хойд есдүгээр дүрийн хувилгааныг олж, тодруулан залахыг хүсч, зөвлөн хэлэлцээд, улмаар ойр орчмын хошуудад төрсөн бага насны хөвгүүдийн дотроос эрж, шинж билиг төгөлдөр хэдэн хөвгүүдийн нэрсийг сонгожээ. Тэд эхний удаа зэргэлдээ бүхий нутагтай Цэцэрлэг Мандлын аймгийн Дилова, Дарав бандида зэрэг том хутагт нарт толилуулан “шинжлүүлсэнд мөнхүү хөвгүүдийн дотроос Дэлгэрхан уулын хошууны Ням, Наранжаргалант уулын хошууны Гэлэгдэмбэрэл, Манзушир нарын гурван хөвгүүний нэг лав мөн хэмээвч чухам алин болохыг Банчин Эрдэнээр заалган”¹ тодруулсугай хэмээжээ. Ийнхүү тэд зөвшин Товуудорж, Ванчин, Дашхүү² гэсэн гурван хүнийг сонгож тэдэнд “мөнхүү хөвгүүн гурвын нэрийг бусад хөвгүүдийн нэрсийн хамт” авхуулан өгч, тухайн үед Хятад, Өвөр Монголд ирээд байсан есдүгээр дүрийн Банчин богд Гэлэгнамжил(1883-1937)-ын “гэгээн дор бараалхуулан айлтгаж заалган олж”

¹ МУУТА. Эрдэнэ Шанзодвын данс А-72.

² МУУТА. Х-1, Д-2, ХН-36. тал 72.

тодруулан хутагтынхаа хойд дүрийг тахиглахаар тогтжээ. Иймээс даруй энэ учраа Шашны Хэрэг Эрхлэх газарт уламжлав. Шашны Хэрэг Эрхлэх газраас уг хэргийг авч хэлэлцээд "... шар, хар олон шавь нар багш Жалханз хутагт хувилгааныг залж тахиглахыг хүссэн нь өөрсдийн дур сүсэг болох тул тэдний олны саналын ёсоор болгон явуулбаас зохих мэт боловч манай газраас эрхлэн хязгаар нэвтрүүлэн явуулж үл болох учрыг гаргаж зааж тогтоох ажаамуу"³ гээд үүнийг дээш нь Намын Төв Хороонд 1925 оны 12 сарын 14-нд дугаар 281 тоот бичгээр өргөсөн байна⁴. Намын Төв Хороо 1925 оны 12 сарын 21-ний тэргүүлэгчдийн хуралд энэ асуудлыг ерөнхий сайд, гишүүн Б.Цэрэндоржийн оруулж ирсний дагуу авч хэлэлцээд "...хүргүүлэн ирсэн энэ хэргийг үүгээр авч хэлэлцэхийг хэрэгсэхгүй"⁵ гэж тогтоожээ. Үүний дараа Шашны Хэргийг Эрхлэх газраас эл учрыг дахин Засгийн газарт өргөн мэдүүлснээр Засгийн газраас 1925 оны 12 сарын 25-ны өдрийн 46 дугаар хурлын 6 дугаар зүйлд тусгайлан авч хэлэлцээд "уг хэргийг үүгээр авч хэлэлцэх зүйл үгүй, Шашны Хэргийг Эрхлэх Газраас эрхлэн шийтгэвээс зохих явдлыг Засгийн газраас эрхлэн гүйцэтгүүлэхээр тогтов"⁶ гээд буцаан шилжүүлжээ.

Энэ үед Нам, засгаас уг асуудалд хандан шууд зөвшөөрөл олгох, эсвэл хориглох тухай ямар нэг тодорхой шийдвэр гаргахаас удаа дараа эрс татгалзаж байсан энэ байдлыг үзэхэд, ерөнхий сайд Б.Цэрэндорж тэргүүтэй тухайн үеийн удирдагчид 1924 оны анхдугаар Үндсэн хуульд заасан шашны хэргийг төрөөс тусгаарлаж, шашин шүтэх, эс шүтэх эрхийг ард иргэдийн сайн дурын хэрэг болгосон үндсэн зарчим(төр, шашныг тусгаарлан явуулах)-ыг хүндэтгэн үзэж, төрөөс шашны дотоод асуудалд шууд оролцож хууль зөрчихөөс зайлсхийсэн бололтой.

Улмаар анхдугаар Үндсэн хуулийн 1-р бүлгийн 3-аар зүйлийн 6-д заасан "Тус улсын харъяат аливаа хүний шүтэх итгэх явдалд бүрнээ эрх чөлөө олгохын тул шашны хэргийг улс төрийн хэргээс тусгаар байгуулж, шашин шүтлэгийн явдлыг өөр өөрийн дур сүсгээр болговол зохино"⁷ гэснийг баримтлан, харъяат шавь нарын уул хүсэлтийг Шашны Хэргийг Эрхлэх газраас "... ёсоор явуулахаар зөвшөөрөн толилж, уул очсон хүмүүсийг цааш хязгаар нэвтрүүлэн явуулж Банчин богдод бараалхуулан эл хөвгүүдийн нэрсийг шинжлүүлсэн"⁸ ажээ.

Банчин богдоос сунтаг шүүж "Лувсангийн хөвгүүн Чойжил буюу Тэрчлэхийн хөвгүүн хэмээхээр битүүлэг үсэг тоо олныг тавих зэргээр тодорхойгүй заасан... боловч хамт буулгасан солдэвын дотор Гэлэгдэмбэрэл хэмээн бичсэн"⁹ байжээ. Гэтэл тэр үед Хан тайшир уулын аймгийн Наранжаргалант уулын хошууны

³ МУУТА. Х-1, Д-2, ХН-36. тал 73. МУМАН-ын Баримтын төв. Х-4, Д-1, ХН-489. тал 73. МУМАН-ын Баримтын төв. Х-4, Д-1, ХН-491. тал 137.

⁴ МУМАН-ын Баримтын төв. Х-4, Д-1, ХН-489. тал 73.

⁵ МУУТА. МАН-ын Баримтын төв. Х-4, Д-1, ХН-365. тал 77.

⁶ МУУТА. Х-1, Д-2, ХН-36. тал 73.

⁷ БНМАУ-ын Их, Бага хурлын тогтоол, Үндсэн хууль, тунхгууд. Улсын хэвлэлийн газар УБ., 1956 он. тал 31.

⁸ МУУТА. Эрдэнэ Шанзодвын данс А-72.

⁹ МУУТА. Х-1, Д-2, ХН-304. тал 108.

Лувсангийн хөвгүүн Чойжил гэгч нь нэгэнт урьд наснаас нөгчин жил алсалсныг сая мэдсэн байна. Иймээс хар, шар олон шавь нар битүүлэг үг үсгийг тайлбарлан чадахгүй, хэрхэхийн тулгуурыг эс олохдоо уг учрыг Дилов, Дарав бандида хутагт нараар дахин шинжүүлсэнд Наранжаргалант уулын хошууны Дэлгэр-Уулын сумны Баатарын аравны хүүхэн Саруулын дөрвөн настай Гэлэгдэмбэрэл хөвгүүн нь “лавтай мөн хэмээн нэрийг тодорхой заасан хэрэг мөн болно”¹⁰ хэмээжээ. Энэ нь нутгийн олон шавь нараас “тэрхүү Гэлэгдэмбэрэл хөвгүүний шинж билиг төгөлдөр хэмээхийг удаа дараа сонсож, мэдэцгээж харьяат хутагтын хойд хувилгаан лав мөн болов уу хэмээн тааварлан хэлэлцэж сүсэглэн байсан саналтай яг нийлэлцсэн” байна. Иймээс Жалханзын хүрээ буюу Равданчойнхорлин хийдийн хэргэмтэн, шавь нараас багш самади хутагтын хойд дүрийн хувилгаан хүү Гэлэгдэмбэрэлийг харьяат хийдийн газар ширээнд нь залж тахилан, сүсгээр суулгаж, эрдэм номд боловсруулан, элдэв хэрэглэлийг хувь хувиас сайн дураар тусламжлан гүйцэтгэхийг хичээнгүйлжээ.

Гэтэл 1926 оны 9 сарын 3-нд Засгийн газраас “Тус улсын төр, шашны хэргийг тусгаарлан явуулах тухайн дүрэм”-ийг баталж, түүний 2-р бүлгийн 12-р зүйлд “... жинхэнэ төрөл дурдсан хувилгаадыг тодруулах гэх аваас тухай бүр засгийн газраа лавлан мэдүүлж, хянан шийтгэвэл зохино”¹¹ хэмээн заажээ. Жалханз хутагт нь язгуураас жинхэнэ төрөл дурьдсан Халхын тамгатай хутагт тул хууль дүрмийн ёсоор Равданчойнхорлин хийдийн лам мэдээчин нараас Дэлгэр хан уулын хошууны Дашлин хийдээр уламжлуулан Гэлэгдэмбэрэл хөвгүүнийг харьяат шавь нарын хүссэн ёсоор ширээнд нь “залуулахыг тогтоон шийтгэж, дагаж явуулахыг”¹² гуйн хүсч 1927 оны 7 сарын 10-наа Бүх Шашны Хэргийг Эрхлэх газарт бичиг өргөжээ.

Бичгийг уг газраас авч үзээд “ёсоор явуулан гүйцэтгэхэд татгалзах явдалгүй”¹³ боловч хууль зүйлийн ёсоор тогтоон шийтгэхийг гуйн Дотоод Явдлын Яамнаа өргөснийг, тус яамнаас 1927 оны 11 сарын 3-нд хэлэлцээд, жинхэнэ төрөл дурдсан хувилгаадыг тодруулахад тухай бүр засгийн газарт мэдүүлж шийдвэрлэх дүрмийн ёсоор Засгийн газарт өргөн толилуулжээ. Үүнийг Засгийн газраас хэлэлцээд, Жалханз хутагтын хойд дүрийг Банчин Эрдэнээр сунтаг шүүлгэхэд Чойжилын нэрийг тэргүүнд заасан боловч хамт буулгасан Солдэвын дотор Гэлэгдэмбэрэл хэмээн бичсэн, мөн битүүлэг үсэг тоо олныг тавих зэргээр тодорхойгүй заасан нь “үнэхээрийн маш үйлс саармаг болсон бөгөөд тогтоон шийдэхэд нэн ч бэрхтэй, зүй нь дахин лавлан мэдэж хэрхэн учрыг үнэн баримттайгаар сайтар тодорхойлуулан ирүүлж гүйцэтгэн шийтгүүлвээс зохих”¹⁴ хэмээн тогтож, үүнийг Дотоод Явдлын Яамнаа явуулж шийтгүүлхээр болжээ. Дараа жил нь буюу 1928 оны 7 сарын 20-нд Засгийн газраас Намын Төв Хороонд “Жалханз хутагтын

¹⁰ МУУТА. Эрдэнэ Шанзодвын данс А-72.

¹¹ Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. Гуравдугаар боть. 1926 VI сар – 1936 он. УБ., 2010. тал 27.

¹² МУУТА. Эрдэнэ Шанзодвын данс А-72.

¹³ МУУТА. Эрдэнэ Шанзодвын данс А-72.

¹⁴ МУУТА. Х-1, Д-2, ХН-304. тал 109.

хувилгааныг тодруулах тухай хэргийн учир дутагдсан зүйлийг дахин тодорхойлон гаргаж тогтоомуу хэмээн 326 тоот хуудас хүргэж ирсэн тул уг бичгийг Төвд үсгээр тайлбарласан хуудас гурвын хамт хүргүүлбэй, хэрхэхийг тогтоон ирүүлмой”¹⁵ хэмээжээ. Гэвч НТХ-оос хэрхэн тогтоон шийтгэсэн тухай баримтыг архиваас энэ удаа бид олсонгүй.

Ийнхүү Монгол улсын ерөнхий сайд агсан С.Дамдинбазарын хойд дүр, Халх Монгол дахь Жалханз хутагтын есдүгээр хувилгаанаар тодорсон Гэлэгдэмбэрэл хүүг харьяат хутагтын шавь сүсэгтэн олноос хүрээ хийдэд нь залж, шашин номын ёсоор явуулах гэсэн оролдлого, үйл хэрэг, тэдний чин хүсэл талаар болсон юм.

1927 он гэхэд Богд ба бусад хутагт хувилгаадыг тодруулах эсэх асуудалд засгийн газар зарчмын хувьд тодруулах шаардлагагүй гэсэн чиг шугамыг барихад хүрчээ. Учир нь 1927 оны 1 сард Коминтерноос Монголын асуудлаар гаргасан тусгай тогтоолдоо “Богдын тухай бас шинэ хутагт хувилгаадыг өргөмжлөх... асуудлаар”¹⁶ хэрхэвч буулт хийж болохгүйг хатуу сануулсан байв. Иймээс Жалханз хутагтын 9 дүгээр дүрийг Засгийн газраас шууд батлах боломжгүй байсан тул Гэлэгдэмбэрэл хүүд элдэв шалтаг эрж түтгэлзүүлсэн нь арга мэх байсан магад. Ер нь Богд хутагтыг таалал болсны дараа Бүгд найрамдах засаг тогтсон шинэ нөхцөлд эхлэн, хууль дүрмийн ёсоор Жалханз хутагтын хойд дүрийг тодруулж, ширээнд нь залах гэсэн энэ цаг хугацаа бол мөн VIII Богд Живзүндамбын хойд дүрийг тодруулах гэсэн оролдлого, түүнийг төрөөс хэрхэн шийдвэрлэхтэй холбогдсон цаг үетэй яг давхцаж байсныг энд онцлон тэмдэглүүштэй юм. Иймээс төрөөс Богдын хойд дүрийг хэрхэн шийдвэрлэхээс шалтгаалж бусад хутагтын асуудал шууд хамаарч байв. Түүхч эрдэмтэн З.Лонжид абугайн бичсэнээр, Намын V Их хурал(1926 оны 9.26 эхэлсэн)-ын шийдвэрийг мөн оны эцсээр хуралдсан Улсын III Их хурал зөвшөөрч Живзүндамбын шинэ дүр залах эсэхийг “Далай ламд айлтгаж явуулсан зүйтэй болжээ” гэсэн нь “... чухамдаа бол өргөн олны шаардлагыг түр зуур зогсоох хэмээсэн арга мэх байлаа гэхэд хэтрүүлэл болохгүй мэт”¹⁷ гэсэнтэй санал нэгдэж, төрөөс Жалханз хутагтын хойд дүр Гэлэгдэмбэрэлийг “хянан шийтгэх”(батлах, зөвшөөрөх) тухайд ч мөн адил цаг хожиж байсан магад.

Нөгөө талаар, Жалханз хутагт бол Ардын засаг тогтсоны дараа шашны талаасаа ч тэр, төрийн зүтгэлтнийхээ хувьд ч тэр Богд хааны дараа орох нэр нөлөө бүхий хүн байсан гэдгийг түүхчид өгүүлдэг. Гэтэл 1923 онд Түвдээс дүрвэн гарсныхаа дараа 1926 оны сүүлчээс эхлэн Зөвлөлт, Монголын дайсан этгээд болох Хятадын Манжуурын цэргийн эрхтэн Жан Золины дэмжлэгийг хүртэх болсон есдүгээр дүрийн Банчин богдын шүүн тодруулснаар Жалханз хутагтын хойд дүрийг хүлээн зөвшөөрнө гэдэг ЗХУ, Коминтерний удирдагчдад зөвшөөрч эс чадах зүйл байсан нь лавтай.

Жилийн дараа буюу 1928 оны сүүлээр хуралдсан Улсын V Их хурлын заалтыг

¹⁵ МУУТА. МАН-ын Баримтын төв. Х-4, Д-2, ХН-561. тал 60.

¹⁶ Коминтерн ба Монгол.(баримтын эмхтгэл). Эрдэм шинжилгээний удирдагч Ч.Даидаваа, В.П.Козлов. УБ., 1996. тал 134.

¹⁷ Харнууд З.Лонжид. Түүх сурахуй. УБ., 2016. тал 19.

үндэслэн 1929 оны 2 сарын 15-нд Засгийн газрын эрхлэх товчооны 24 дүгээр хурлын 9 дүгээр тогтоолоор Богд болон “аливаа хутагт хувилгаадыг залах тодруулах гэхийг бүрмөсөн зогсоох”¹⁸ хэмээн хуулиар хориглосон түүхтэй.

Харин 1924 онд тухайн үеийн Хантайшир уулын аймгийн Наранжаргалант уулын хошууны Мөнгөн уулын өвөр Шуугийн халзангийн ам хэмээх газар төрсөн Гэлэгдэмбэрэл хүү нь хожим цэрэгт явж, Хөвсгөл аймгийн Тосонцэнгэл, Их уул, Цагаан-Уул сумдад багшилж, аймгийн боловсролын хэлтэст байцаагч зэрэг ажил хийж, ард олны дунд нууцхан шүтэгдэж явсаар 1960-аад оны сүүлч хүртэл¹⁹ амьдарсан тухай мэдээ байдгийг цаашид нягтлан судлуштай юм.

Ашигласан материал

1. МУУТА. Эрдэнэ Шанзодвын данс А-72.
2. МУУТА. Х-1, Д-2, ХН-36.
3. МУУТА. Х-1, Д-2, ХН-304.
4. МУУТА. МАН-ын Баримтын төв. Х-4, Д-1, ХН-365.
5. МУ.МАН-ын Баримтын төв. Х-4, Д-1, ХН-489.
6. МУМАН-ын Баримтын төв. Х-4, Д-1, ХН-491.
7. МУУТА. МАН-ын Баримтын төв. Х-4, Д-2, ХН-561.
8. БНМАУ-ын Их, Бага хурлын тогтоол, Үндсэн хууль, тунхгууд. Улсын хэвлэлийн газар УБ., 1956.
9. Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хууль түүнд холбогдох зарим актын эмхэтгэл. УБ., 1972.
10. Коминтерн ба Монгол.(баримтын эмхтгэл). Эрдэм шинжилгээний удирдагч Ч.Дашдаваа, В.П.Козлов. УБ., 1996.
11. Монголын хууль тогтоомжийн түүхэн эмхтгэл. Гуравдугаар боть. 1926 оны VI сар – 1936 он. УБ., 2010.
12. А.Ариунболд. Монголчуудын нэгэн зүйл шүтээний тухай. Философи, шашин судлал. XV. УБ., 2013.
13. Харнууд З.Лонжид. Түүх сурахуй. УБ., 2016.

ABSTRACT

This article will state the historical events of the unsuccessful wish of the locals and faithful ones to find the reborn khutagt who can take the place of fallen Jalkhanz khutagt Damdinbazar, the chosen one from among their monks and successors within their own lands to continue the will of his own predecessor in summer of 1923.

The Article based on archival materials, which are stocked in fund of General Authority for Archives of Mongolia.

¹⁸ Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Үндсэн хууль түүнд холбогдох зарим актын эмхэтгэл. УБ., 1972. тал 220.

¹⁹ А.Ариунболд. Монголчуудын нэгэн зүйл шүтээний тухай. Философи, шашин судлал. XV. УБ., 2013. тал 218.